



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР




УДИРДЛАГЫН ДҮН
ШИНЖИЛГЭЭ ХИЙХ
ЖУРАМ

ЧИНГИС ХОТ
2023 ОН



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ



Баталсан:

Баримт бичгийн дугаар: Хэ АЗДТГ ISO /МББ/12

(гарын үсэг)

Хянасан:

(гарын үсэг)

Ж. Гантулга
Засаг даргын Тамгын газрын
дарга

Ц. Ганчимэг
Хяналт-шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн дарга

Эх хувь	Дардас
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	

ЧИНГИС ХОТ
2023 ОН

Баримт бичгийн үндсэн мэдээлэл

Баримт бичгийн хариуцагч	Тушаалын дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
.....

Нэмэлт өөрчлөлтийн тухай мэдээлэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
...

Нэг. Зорилго

Аймгийн Засаг даргын Тамгын газар нь байгууллагын чанарын менежментийн тогтолцоо, байгууллагын стратегийн чиг хандлагад нийцсэн, тохирсон, үр нөлөөтэй байнга хэрэглэх байдалд нь төлөвлөсөн давтамжтайгаар дун шинжилгээ хийх ажлыг хэрхэн явуулахыг тогтооно.

Хоёр. Хамрах хүрээ

Энэ журам нь байгууллагын ерөнхий бичиг хэрэг, санхүүгийн зэрэг чанарын холбогдолгүй баримт бичигт хамаарахгүй.

Гурав. Норматив иш таталт

Энэхүү журамд дараах баримт бичгийн сүүлчийн хэвлэлтийг үндэслэл болгон тусгаж, иш татан хэрэглэнэ. Үүнд:

- MNS ISO TR 10013-2001 Чанарын удирдлагын тогтолцооны баримт бичигт зориулсан заавар
- MNS ISO 9001:2016 (ISO 9001:2015) Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага
- MNS ISO 9000:2017 Чанарын менежментийн тогтолцоо – Суурь асуудал, тайлбар толь
- MNS ISO 9004:2016 Байгууллагын амжилтыг тогтвортой байлгах менежмент – Чанарын хандлага

Дөрөв. Нэр томъёо, тодорхойлолт

4.1. Энэхүү журамд заасан нэр томъёонуудыг MNS ISO 9000:2017 Чанарын удирдлагын тогтолцоо – Суурь асуудал, тайлбар толь стандартад тодорхойлсноор ойлгоно.

Тав. Дүн шинжилгээ ба түүний орц

5.1. Тус байгууллага удирдлагын тогтолцоо ба бусад үйл ажиллагааны тохиромжтой, үр нөлөөтэй байдлыг хангах шаардлагатай өөрчлөлт, сайжруулалт хийх зорилгоор удирдлагын дүн шинжилгээг хийнэ.

5.2 Удирдлагын дүн шинжилгээг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор багтаан чанарын менежер зохион байгуулна.

5.3 Удирдлагын дүн шинжилгээний цуглуулсан мэдээлэл, өгөгдөл, баримт бичигт анализ хийх замаар удирдлагын дүн шинжилгээг явуулна.

5.4 Удирдлагын дүн шинжилгээний орц нь дараах мэдээллийг багтаасан байна. Үүнд:

- a) Байгууллагад хамааралтай дотоод, гадаад орчны өөрчлөлт
- b) Зорилтын биелэлт
- c) Тухай онд явуулсан чанарын гадаад болон дотоод аудитын үр дүн;
- d) Хэрэглэгч, үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол, санал, хүсэлт, бусад мэдээлэл;
- e) Сэргийлэх болон залруулах арга хэмжээ;
- f) Гадны байгууллагаас хийсэн үнэлгээ
- g) Бодлого, журмын нийцтэй байдал
- h) Удирдлагын өмнөх дүн шинжилгээний мөрөөр авсан арга хэмжээ;
- i) Ирэх онд явуулах аудитын болон удирдлагын дүн шинжилгээний хөтөлбөрийн төсөл.
- j) Үйл явцын гүйцэтгэл ба чанар
- k) Сайжруулах талаар гарсан зөвлөмжүүд

Зургаа. Дүн шинжилгээний гарц түүний үр дүнг ашиглах

6.1 Удирдлагын дүн шинжилгээний үр дүн болох гарц нь дараах зүйлд хамаарах шийдвэр, арга хэмжээг багтаана. Үүнд:

- a) Чанарын удирдлагын тогтолцооны болон түүний үйл явцуудын үр нөлөөг сайжруулах;
- b) Байгууллагын үйл ажиллагаанд холбогдолтой бодлогыг боловсруулах зэрэгт хамаарах шийдвэр болон арга хэмжээ
- c) Албан хаагчдын хандлага, ёс зүй, ур чадварыг сайжруулах боломж

6.2 Чанарын менежер нь удирдлагын дүн шинжилгээний тайланг энэ журмын 1-р хавсралтад заасны дагуу гаргана.

6.3 Байгууллагын удирдлага нь дүн шинжилгээний тайланг авч үзэн, журмын 2-р хавсралтад заасны дагуу төлөвлөж аливаа гүйцэтгэл сайжруулах хэрэгсэл болгон ашиглуулна.

6.4 Дээрх шийдвэрийг чанарын менежер холбогдох алба, нэгжүүдэд мэдээлж хүргэнэ.

--оOо--

**БАЙГУУЛЛАГЫН 20 ОНЫ УДИРДЛАГЫН
ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

№	Үзүүлэлт	Өөрчлөлт /хувь/	Тоо хэмжээ		Тайлбар
			урьд оных	энэ оных	
1	Гадаад аудитын үр дүнд авсан залруулах арга хэмжээний тоо Үүнээс:				
2	Дотоод аудитын үр дүнд авсан залруулах арга хэмжээний тоо Үүнээс:				
3	Хэрэглэгч, үйлчлүүлэгчдээс ирсэн санал, хүсэлт. Үүнд:				
4	Хэрэглэгч, үйлчлүүлэгчдээс ирсэн гомдол. Үүнд:				
5	Удирдлагын өмнөх дүн шинжилгээний мөрөөр авсан арга хэмжээ				
6	Чанарын удирдлагын тогтолцоонд нөлөөлөхүйц өөрчлөлт				
7	Боловсон хүчиний мэдлэг, мэдлэгийг дээшлүүлэх талаар авсан арга хэмжээний тоо. Үүнд: -Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажилтны тоо				
8	Чанарын удирдлагын тогтолцооны баримт бичгийг боловсронгуй болгох талаар авсан арга хэмжээний тоо				

Хавсралт -2

БАЙГУУЛЛАГЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ
ЧИГЛЭЛЭЭР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Төсөв
1				
2				
3				
4				
5				

--оОо--



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ЧАНАРЫН УДИРДЛАГЫН
ТОГТОЛЦОО ISO 9001:2015 СТАНДАРТЫГ НЭВТРҮҮЛЭХ
АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН УДИРДЛАГЫН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 06 дугаар сарын 23

Дугаар 01

Чингис хот

Хурал 2023 оны 06 дугаар сарын 23-ний 15.02 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд эхлэв. Хурал 100%-ийн ирцтэй байв.

Хуралд: Аймгийн Засаг дарга Ц. Чогсомжав, аймгийн Засаг даргын орлогч Л. Батсайхан, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж. Гантулга, хэлтсийн дарга нар болон Д. Өнөрцэцэг ахлагчтай дотоод аудитын багийн гишүүд 100 хувийн ирцтэй оролцов.

Хэлэлцсэн нь:

Дотоод аудитын тайлангаас гарсан санал, дүгнэлтийн талаар

Сонссон нь:

Дотоод аудитын багийн ахлагч Д. Өнөрцэцэг:

Чанаарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2016 нэвтрүүлж байгаатай холбогдуулан мөн анхдагч аудитад орох хүсэлт хургуулэхэд бэлэн эсэхийг шалгах, сайжруулах зорилгоор аудитын багийн бүрэлдэхүүн 06 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зэлжит аудит хийлзээ. Тус аудитаар том үл тохирол илрээгүй боловч сайжруулах 6 асуудал гарсныг танилцуулж сайжруулах арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай байна. Үүнд:

-Алдаа, амжилтын дэвтэр дээр мэргэжилтнүүд бүртгэл хийгээгүй байв.

-Стандартыг хэрэгжүүлэхэд ачааллыг тэнцвэржүүлэх

-Танилцуулга, мэдээллийг хүлээлгийн танхим дахь телевиз болон байгууллагын вэб сайт болон фэйсбууц хуудсаар олон нийтэд хүргэж байгаа боловч баримтжуулж, бүртгэл хөтлөөгүй.

-Угтах үйлчилгээнд ажиллаж буй ажилтны ажиллах орчин нөхцлийг сайжруулах, анхан шатны мэдээллээр хангаж сургамаар байна.

-Бүтээмжийн багийн хийсэн ажлыг үнэлэх хэрэгтэй байна.

-Удирдлагын манлайллыг идэвхжүүлэх.

Ц. Чогсомжав /Засаг дарга/: Засаг даргын Тамгын газар ISO хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай байна. Стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг тухай бүр шийдээд явж байгаа тул ажлынхаа үр дүнг харж баталгаажуулалтаяа ойрын хугацаанд хийлгэх нь зүйтэй.

Ж. Гантулга /Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/: 2022 оноос ISO-г нэвтрүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар томилж нилээдгүй ажлуудыг хийсэн. Ажлын үр дүн эхнээсээ гарч байна. Хийсэн ажлуудаа үнэлүүлж баталгаажуулалтаяа энэ оны 3-р улиралд хийлгэхээр төлөвлөөд ажиллаж байна. Дотоод аудитын багаас гаргасан сайжруулах ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэхэд асуудал байхгүй гэж бодож байна. Үл тохирол болохуйц зүйл илрээгүй тул ойрын хугацаанд батлагаажуулалтын саналаа явуулах шаардлагатай.

Ц. Ганчимэг /Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга/: Стандарт нэвтрүүлэхэд шаардлагатай баримт бичгүүдийн ихэнх нь манай байгууллага дээр



хэрэгжиж байгаа зүйлүүд ажиглагдсан. Гол нь бүртгэл, баримтжуулалт байхгүй байсан. Нэгэнт тодорхой хэмжээний хөрөнгө, цаг заваа зарцуулж хийсэн ажлаа үнэлүүлж баталгаажуулалтаа хийлгэх нь зүйтэй.

Д.Өнөрцэцэг: Дотоод аудитын багаас гаргасан сайжруулах шаардлагатай ажлуудаа хийж гүйцэтгээд, бүтээмжийн багийн ажлыг үнэлэх хэрэгтэй байх баталгаажуулалт хийлгэх саналтай байна.

Удирдлагын зөвлөлийн гишүүдийн 100 хувийн саналаар ISO 9001:2015 стандартыг баталгаажуулах хүсэлтээ явуулж, баталгаажуулалтаа хугацаанд нь хийлгэхээр шийдвэрлэв.

Хурал 18.10 цагт хаав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Д.Энх - Чингис Б.ЭНХ-УЯНГА*